



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 дугаар сарын 15

Дугаар 02

Улаанбаатар хот

II ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 15.00 цагт Төрийн ордон дахь "Сүхбаатар танхим"-д *Т.С.Г* хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Хонины цэцэг, бог малын мялзан зэрэг малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга
А.Нарантуяа*

2. Улсын онцгой комиссын Шуурхай штабаас өвөлжилтийн талаар авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар

*Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга,
Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга,
бригадын генерал Б.Ууганбаяр*

3. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдлын талаар

*Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун*

4. Цаг агаарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал*

5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр болон Улсын онцгой комиссын гишүүдэд:

1.1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн тогтоолоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29.1.3-т заасны дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамжийг боловсруулж батлуулан хэрэгжүүлэх;

1.2. Аймаг, сумдын Онцгой комисст дэмжлэг үзүүлэх, зудын эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх, эрсдэлийг бууруулах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах шуурхай бүлгүүдийг зудад өртсөн аймгуудад томилж ажиллуулах;

1.3. Улсын нөөцөөс аймаг сумдад өвс, тэжээл, хүнс, шатахуун хөнгөлөлттэй үнээр олгох, Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх;

Хоёр. Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Улсын онцгой комиссын Шуурхай штабын дарга, бригадын генерал Б.Ууганбаяр нарт:

2.1. Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, айл өрхүүдэд хүнс, түлээ түлш, малын тэжээл хүргэх ажлыг аймаг, сумдын Онцгой комисстой хамтран өргөн хүрээнд зохион байгуулах, уг ажилд шаардлагатай хүн, хүч хэрэгслийг нэмэлтээр дайчлан гаргах,

2.2. Дайчлагдан ажиллаж буй техник хэрэгсэлийн бүрэн бүтэн байдал, алба хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;

Гурав. Боловсрол шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Соёлын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ч.Номин, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн Нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Ганхүү, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга Т.Ганзул нарт:

3.1. Зудад нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээ алдаж, малгүй болсон малчдын судалгааг нарийвчлан гаргаж, эрсдэлд орсон малчин айл өрхүүдэд чиглэсэн нийгмийн хамгаалал, халамжийн бодлогыг хэрэгжүүлэх, малжуулах болон бусад төсөл хөтөлбөрүүдэд хамруулах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээг Улсын онцгой комисс, Засгийн газарт тухай бүр танилцуулах;

3.2. "Малчдад туслах аян"-ыг олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэд, төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, нэгдсэн удирдлага зохицуулалтаар хангах;

Дөрөв. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Сүхболд, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Малын гоц халдварт хонины цэцэг, бог малын мялзан өвчний халдварын голомтыг хяналтад авах, тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

4.2. Хорио цээрийн дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт бүх төрлийн тээврийн хэрэгсэл, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлыг зохион байгуулах;

4.3. Малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, гоц халдварт өвчний вакцин, тарилга, шаардлагатай эм бэлдмэлийн нөөцийг яаралтай бүрдүүлэх, татан авах, орон нутагт хүргэх, вакцинжуулах ажлыг шуурхай зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах;

4.4. Хонины цэцэг, бог малын мялзан өвчний халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэхэд холбогдон гарсан зардлыг аймаг, орон нутгийн батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх;

Тав. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзориг, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

5.1. Малчдыг эрт илрүүлгийн үзлэг, оношлогоо, шинжилгээнд бүрэн хамруулах, алслагдсан сум, багуудад эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, холбогдох зардлыг батлагдсан төсвийн хүрээнд шийдвэрлэх;

5.2. Сумын эрүүл мэндийн төвийн алсын дуудлагад явах туулах чадвар сайтай эмнэлгийн тусламж үйлчилгээний автомашины хангалтыг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрөнгийг Засгийн газрын хуралдаанаар шийдвэрлүүлж, худалдан авалт болон бусад шаардлагатай арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

Зургаа: Аймаг, нийслэлийн Засаг дарга, бүх шатны Онцгой комисст:

6.1. Зудын эрсдэлийг бууруулах, айл өрхийн амьжиргааг дэмжих арга хэмжээний хүрээнд Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу гамшгийн болон орон нутгийн нөөцийг нэмж бүрдүүлэх, орон нутгийн нөөцийг дайчилж хүнс, өвс тэжээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хаагдсан зам давааг нээх, айл өрхүүд рүү зам гаргах ажлыг шуурхай, тогтмол зохион байгуулж ажиллах;

6.2. Орон нутгийн төсвийн давсан орлогыг малчдад туслах арга хэмжээнд зарцуулах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажиллах;

6.3. Дотоод нөөц боломжоо ашиглан аймаг, сумын аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг нэмэгдүүлэн малчдад олгох ажлыг шуурхай зохион байгуулж, зудын эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Долоо. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын

гишүүн Х.Болорчулуун, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын дарга Н.Билгүүн, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

7.1. Өвөлжилт хүндэрсэн аймаг, сумдын Онцгой комисст зудын эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн дэмжлэг үзүүлэх тооцоо, судалгаа гаргаж Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

7.2. Стратегийн хүнс, бараа, бүтээгдэхүүний хомсдол, үнийн хөөрөгдөл үүсэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хяналт тавих;

Найм. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ц.Даваасүрэн, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

8.1. Шар усны үерээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж үерийн эрсдэл бүхий газар айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллах;

Ес. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзул, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Улсын онцгой комиссын гишүүн Л.Оюунжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

9.1. Цаг агаарын болон шар усны үерийн мэдээ, сэрэмжлүүлэг мэдээллийг иргэд олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр шуурхай тогтмол хүргэх, урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээнд тогтмол зохион байгуулж ажиллах;

Арав. Улсын онцгой комиссын гишүүд, бүх шатны Онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албадад:

10.1. Улсын хэмжээнд 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар объектын гал түймрийн 594 тохиолдол бүртгэгдэж гал түймэрт 22 иргэн өртөж нас барж, 22 иргэн түлэгдэж, 2 иргэн бэртэж, 7 иргэн угаартсан байна. Объектын гал түймрийн дуудлага, мэдээллийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад гал түймрийн тоо 15.1 хувиар, гал түймэрт өртөж нас барсан хүний тоо 3.1 дахин өссөн байна. Иймд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг 7 хоног бүр Улсын онцгой комисст танилцуулж ажиллах;

10.2. Улсын онцгой комиссын 2024 оны “Шар усны үер, үерийн аюулаас урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай” 01, “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг бүх шатанд хангаж ажиллах;

10.3. Технологийн горим зөрчигдөх, хөдөлмөрийн аюулгүй байдал алдагдсаны улмаас аюултай ачаа тээвэрлэж буй тээврийн хэрэгсэл осолдох, химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргээр хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчин, барилга байгууламжид ноцтой хохирол учруулж болзошгүй ослоос урьдчилан сэргийлэх, салбарын хяналтын үйл ажиллагааг эрчимжүүлэх;

10.4. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Улсын онцгой комиссын даргын 2023 оны 8 дугаар тушаалаар байгуулагдсан Шуурхай штабыг шаардлагатай мэдээ мэдээллээр хангах, харилцан хамтран ажиллах, Шуурхай штабт томилогдон ажиллаж байгаа албан тушаалтныг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах;

Арван нэг. Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгаланд:

11.1. Нийт нутгаар их хэмжээний цас орж хаваржилтын нөхцөл байдал хүндэрч байгаатай холбогдуулан орон нутгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа, улиралын амралтын хуваарьт уян хатан зохицуулалт хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Арван хоёр. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Энхбаяр, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун нарт:

12.1. Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан ажлын хэсэг байгуулж малын тэжээл (хивэг, хорголжин, багсармал, овъёос, эрдэс, уургийн нэмэгдлүүд, амьтны тэжээл), гурилын импортын барааг гаалийн албан татвараас чөлөөлөх хууль тогтоомжийн төсөл яаралтай боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж Улсын их хуралд яаралтай горимоор өргөн мэдүүлэх;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ